



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 1/19

Тавин

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Өвөр-Урт багийн нутаг Хажуу гэдэг газар Галзуу өвчний голомт хумигдаж шинж тэмдэг дахин илрээгүй тул хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Голомттой бүсийн мал эмнэлгийн ариун цэвэр ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг стандартын дагуу авч хэрэгжүүлэх, мал эмнэлгийн тасгийн хяналт дүгнэлтийг үндэслэн хязгаарлалтын дэглэмжийг 2023 оны 03 сарын 15-ны өдрөөс цуцалсугай.

3. Хязгаарлалтыг цуцалсан мэдээллийг малчид, иргэдэд хүргэж ажиллахыг Багийн засаг дарга нар, Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (А.Цолмонбаатар) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ